



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид 2 барилга байгууламж
бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон нийт 6,238,492,626 (зургаан тэрбум хоёр зуун гучин найман сая дөрвөн зуун ерэн хоёр мянга зургаан зуун хорин зургаа) төгрөгийн өртөг бүхий хавсралтад дурдсан 2 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.


ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100346

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 100
дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Нийслэлийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо	2022	3,403,496,906	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
2	Сүхбаатар дүүргийн 216 дугаар цэцэрлэгийн цогцолбор барилга	Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо	2022	2,834,995,720	
НИЙТ ДҮН				6,238,492,626	